



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/345

Улаанбаатар хот

Г Төлөвлөгөө батлах тухай Т

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2017 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлогын 2.4.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эм зүйн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө /2017-2020/-г хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Эм, үйлдвэрлэл, технологийн газрын дарга /Л.Мөнхтулга/, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн өрөнхий захирал /Б.Нарантуяа/ нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Баярт/-т даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

081097

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 09 сарын 04-ны өдрийн
11 дугаар тушаалын хавсралт
1345

Эм зүйн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг сайжруулах
үйл ажиллагааны төлөвлөгөө

д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх үе шат /оноор/				Хэрэгжүүлэгч байгууллага	Шалгуур үзүүлэлт				
		2017	2018	2019	2020						
НЭГ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ											
Хүрэх үр дүн: Эм зүйн салбарын ил тод, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, шударга байдлыг бэхжүүлэх, авлигатай тэмцэх эрх зүйн орчин сайжирна.											
1.1.	Эмийн зохицуулалтад оролцох зарим хорооны ажиллах журамд гишүүдийн ашиг сонирхолын зөрчлийг зохицуулах асуудлыг тусгах		+			ЭМЯ	Эмийн зохицуулалт оролцох зөвлөл, хорооны ажиллах журам ашиг сонирхолын зөрчлийн асуудлыг тусган шинэчлэн батлагдсан байна				
1.2.	Бүртгэлийн мэргэжилтэн болон эм бүртгүүлэгчтэй хийх уулзалтад баримтлах стандарт заавар боловсруулж батлуулах	+				ЭМХТ	Бүртгэлийн мэргэжилтэн болон эм бүртгүүлэгчтэй хийх уулзалтад баримтлах стандарт ажиллагааны заавар боловсруулж батлагдсан байна				
1.3.	Хатуу зохицуулалттай улсад бүртгэгдсэн эмийг таних журам/шалгуурыг боловсруулж батлуулах	+	+			ЭМХТ	Эмийн бүртгэлийн материалын үнэлгээний шалгуур, стандарт ажиллагааны заавар боловсруулж, батлагдсан байна				
1.4.	Бүртгүүлсэн бүтээгдэхүүнд зөвшөөрөгдөөгүй өөрчлөлт хийсэн тохиолдолд баримтлах стандарт ажиллагааны заавар боловсруулж батлуулах	+				ЭМХТ	Бүртгүүлсэн бүтээгдэхүүнд зөвшөөрөгдөөгүй өөрчлөлт хийсэн тохиолдолд баримтлах стандарт ажиллагааны заавар батлагдсан байна				
1.5.	Эм бүртгүүлэх этгээд гомдол гаргахад баримтлах стандарт ажиллагааны заавар боловсруулж батлуулах	+				ЭМХТ	Эм бүртгүүлэх этгээд гомдол гаргахад баримтлах стандарт ажиллагааны заавар батлагдсан байна				

1.6.	Тусгай зөвшөөрөл хүсэгч тал ба үнэлгээ өгөх талуудын уулзалтад стандарт заавар батлуулах		+	+		ЭМЯ	Тусгай зөвшөөрөл хүсэгч тал ба үнэлгээ өгөх талуудын уулзалтад стандарт заавар батлагдсан байна
1.7.	Эмнэлзүйн зохистой дадлын хяналт шалгалтад баримтлах хяналтын хуудсыг боловсруулж батлуулах		+			МХЕГ	Эмнэлзүйн зохистой дадлын хяналт шалгалтад баримтлах хяналтын хуудас батлагдсан байна
1.8.	Хяналт шалгалтын нийцтэй байдлыг шалгах зорилгоор дотоод аудит, дүн шинжилгээ хийх журам боловсруулж батлуулах		+			МХЕГ	Хяналт шалгалтад аудит, дүн шинжилгээ хийх журам батлагдсан байна
1.9.	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг зохицуулж буй журмыг шинэчилж, эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаанд тавих ёс зүйн шалгуур, хянаж шалгах хуудсыг боловсруулж, батлуулах		+	+		ЭМХТ, МХЕГ	Эмийг зах зээлд таниулах үйл ажиллагааг зохицуулж буй журам шинэчлэгдсэн байна, эмийг зах зээлд таниулах үйл ажиллагаанд тавих ёс зүйн шалгуур, хянаж шалгах хуудас батлагдсан байна
1.10.	Эмнэлзүйн туршилт явуулах журмыг боловсронгуй болгох			+		ЭМЯ, мэргэжлийн зөвлөл	Эмнэлзүйн туршилт явуулах журам шинэчлэгдсэн байна
1.11.	Зайлшгүй шаардлагатай эмийг сонгох шалгуурыг боловсронгуй болгох, сонгох удирдамж/стандарт ажиллагааны зааврыг боловсруулах			+		ЭМЯ, ЭМХТ	Зайлшгүй шаардлагатай эмийг сонгох шалгуур шинэчлэгдсэн байна, сонгох удирдамж/стандарт ажиллагааны заавар батлагдсан байна
1.12.	Хугацаа дууссан эсвэл муудсан эмийн хог хаядалтай харьцах стандарт ажиллагааны заавар боловсруулах			+		Эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагууд	Хугацаа дууссан эсвэл муудсан эмийн хог хаядалтай харьцах стандарт ажиллагааны заавар батлагдсан байна

ХОЁР. ЭМ ЗҮЙН САЛБАРЫН САЙН ЗАСАГЛАЛЫГ БЭХЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Эм зүйн салбарт гарах ёс зүйгүй үйл ажиллагаа буурч, сайн засаглал, авлигын тухай мэдлэг сайжирч, ил тод, хариуцлагатай байдал нэмэгдэнэ

2.1.	Эмийн үнийн судалгаа хийх	+			ЭМЯ, АХБ	Судалгааны тайлан олон нийтэд хүртээмжтэй болсон байна
2.2.	Антибиотикийн хэрэглээний судалгаа хийх		+		ЭМЯ, ДЭМБ	Судалгааны тайлан олон нийтэд хүртээмжтэй

						болсон байна
2.3.	Ёс зүйн дүрмийн мөрдөлтийг хянах, хяналтын тайланг мэдээлж хэвших	+	+	+	+	ЭМЯ, ЭМХТ, эм хангамжийн байгууллагууд Ёс зүйн дүрмийн мөрдөлтийг хянасан тайлан олон нийтэд хүртээмжтэй болсон байна
2.4.	Буруутай зүйлийн талаар гаргасан гомдолыг судлан хариуг олон нийтэд мэдээлж хэвших, гарсан гомдолд дүн шинжилгээ хийж, тайланг эм зүйн салбарын үйл ажиллагааны чиглэлээр гаргах хэвших	+	+	+	+	ЭМЯ, ЭМХТ Буруутай зүйлийн талаар гаргасан гомдолд өгсөн хариу болон гарсан гомдолд хийсэн дүн шинжилгээний тайлан олон нийтэд хүртээмжтэй болсон байна
2.5.	Хорооны гишүүдийн ашиг сонирхолын зөрчлийг бүртгэж, мэдүүлгийг үнэлж, зохицуулж, нэгдсэн тайлан гаргаж хэвших		+	+	+	ЭМЯ, ЭМХТ, орон тооны бус ажлын хэсэг Ашиг сонирхолын зөрчлийг үнэлсэн болон зохицуулсан тайлан олон нийтэд хүртээмжтэй болсон байна
2.6.	Бүртгэхээс татгалзсан, хассан, түдгэлзүүлсэн эмийн бүх бүтээгдэхүүний жагсаалт/мэдээний санг бүрдүүлэх		+			ЭМХТ Мэдээний сан бүрдсэн, тогтмол шинэчилдэг байна
2.7.	Тусгай зөвшөөрөл/үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон эсвэл үйл ажиллагаагаа зогсоосон эм хангамжийн байгууллагын нэгдсэн жагсаалт/мэдээллийн сан бий болгож олон нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх		+			ЭМЯ, ЭМХТ Мэдээний сан бүрдсэн, тогтмол шинэчилдэг байна
2.8.	Эмийн компаниас ивээн тэтгэсэн эмнэлгийн мэргэжилтэнд зориулсан мэргэжлийн сургалтыг үнэлж, тайлан гаргаж, мэдээлэх тогтолцоог бүрдүүлэх		+	+	+	ЭМХТ Үнэлгээний тайлан олон нийтэд хүртээмжтэй байна
2.9.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хийсэн зар сурталчилгаанд үнэлгээ хийх		+			ЭМЯ Үнэлгээний тайлан олон нийтэд хүртээмжтэй байна
2.10.	Эмнэлзүйн туршилтыг холбогдох байгууллагад бүртгүүлж, үр дүнг мэдээлж хэвших	+	+	+	+	ЭМЯ, эмнэлэг, судалгааны байгууллагууд Хийгдэж буй эмнэлзүйн туршилтын бүртгэл бий болсон, үр дүн

						нь хүртээмжтэй байна
2.11.	Улсын хэмжээнд хийгдсэн эмнэлзүйн туршилтын үр дүнг үнэлж, тайлан/статистик мэдээлэл гаргах		+		ЭМЯ, холбогдох мэргэжлийн зөвлөл	Үнэлгээний тайлан олон нийтэд хүртээмжтэй байна
2.12.	Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтаас хасагдсан, хүсэлтийг нь буцаасан тухай шийдвэрийг олон нийтэд мэдээлж хэвших			+	ЭМЯ, ЭМХТ	Шийдвэр олон нийтэд хүртээмжтэй байна
2.13.	Улсын салбарт эм худалдан авах ажиллагаанд оролцох байгууллагын урьдчилсан сонголт хийх, шалгарсан эм ханган нийлүүлэх байгууллагуудын жагсаалтыг гарган олон нийтэд мэдээлж хэвших	+			ЭМЯ, ЭМХТ, ТӨБЗГ, АХБ	Урьдчилсан сонголтыг явуулсан, шалгарсан байгууллагын жагсаалт олон нийтэд хүртээмжтэй байна
2.14.	Эмнэлгийн тусlamж үйл ажиллагаанд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн судалгааг жил бүр гаргах	+	+	+	ЭМЯ, ЭМХТ, Эрүүл мэндийн болон эм хангамжийн байгууллагууд	Жил бүр судалгааг хийсэн байна
2.15.	Түгээлтийн системийн гүйцэтгэлийн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх тогтолцоог бий болгох, үнэлж хэвших		+	+	ЭМЯ, ЭМХТ	Түгээлтийн системийг үнэлэх, хяналт шинжилгээ хийх тогтолцоо бүрдсэн, тайлан нь олон нийтэд хүртээмжтэй байна
2.16.	Эмийн ил тод болон хариуцлагатай байдлыг сайжруулах, сайн засаглалыг бэхжүүлэх, авлигаас сэргийлэх чиглэлээр сурталчилгааг тогтмол хийх	+	+	+	ДЭМБ, ЭМХТ, ажлын хэсэг	Жилд 2-с доoshgүй сургалт сурталчилгаа хийсэн байна